



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021 /23/-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.28 № 43

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ  
ЭРДМИЙН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Н.ЯНЖМАА ТАНАА**

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

006020089



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>84,374,898.00</u></b>	<b><u>99,549,012.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	735,450.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	735,450.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	735,450.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	735,450.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	84,374,898.00	98,813,562.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	25,023,641.26	25,881,684.26
35110	Тусгай зориулалттай материал	24,728,349.26	24,728,349.26
35130	Эм боох материал	295,292.00	1,153,335.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,283,866.34	11,283,866.34
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,967,390.40	56,173,011.40
35410	Бичиг хэргийн материал	2,122,750.00	1,688,850.00
35420	Аж ахуйн материал	29,356,827.00	46,492,762.00
35440	Түлш, шатах тослох материал	1,050,000.00	330,000.00
35450	Барилгын засварын материал	7,059,198.00	5,282,784.00
35470	Бусад хангамжийн материал	2,378,615.40	2,378,615.40
35600	Мал амьтад	6,100,000.00	5,475,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,669,700,804.92</u></b>	<b><u>2,119,316,608.03</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,669,700,804.92	2,119,316,608.03
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,353,522,304.90	1,803,269,358.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,368,193,446.00	1,766,631,757.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-193,596,406.78	-284,619,518.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,073,251.39	220,144,498.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-279,140,526.92	-82,918,142.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,610,541.89	100,824,743.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,835,809.65	-54,902,402.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	174,350,418.00	176,920,818.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-44,681,792.49	-61,394,082.11
39217	Ном	16,549,183.46	22,581,686.12
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	316,178,500.02	316,047,250.02
39301	Програм хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-554,999.98	-686,249.98
39303	Бусад биет бус хөрөнгө	315,816,000.00	315,816,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,754,075,702.92</u></b>	<b><u>2,218,865,620.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,754,075,702.92</u></b>	<b><u>2,218,865,620.03</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,754,075,702.92	2,218,865,620.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,850,088,184.62	1,850,088,184.62
51101	Өмч: - төрийн	1,850,088,184.62	1,850,088,184.62
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-4,657,781,359.03	-4,192,991,441.92

51210	Өмнөх үеийн үр дүн	-4,657,781,359.03	-4,657,781,359.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	464,789,917.11
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,561,768,877.33	4,561,768,877.33
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,754,075,702.92</u></b>	<b><u>2,218,865,620.03</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,153,829,516.20</b>	<b>2,801,596,803.66</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>139,938,816.20</b>	<b>569,137,503.66</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	139,938,816.20	569,137,503.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	139,938,816.20	569,137,503.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,435,450.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,938,816.20	566,702,053.66
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,056,700.00</b>	<b>277,951,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,700,834,000.00	1,954,507,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,669,000.00	4,613,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,120,000.00	720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,549,000.00	3,893,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	304,387,700.00	273,338,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,387,700.00	273,338,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,131,448,653.26</b>	<b>2,335,746,886.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,131,448,653.26</b>	<b>2,335,746,886.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,048,039,099.76	2,207,429,379.46
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,368,805,904.45	1,586,455,685.14
210101	Үндсэн цалин	909,061,880.31	938,318,406.88
210102	Нэмэгдэл	284,267,574.10	462,765,042.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,814,292.63
210104	Урамшуулал	175,476,450.04	143,557,943.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	170,784,267.05	198,457,013.77
210201	Тэтгэврийн даатгал	115,742,875.00	126,567,107.82
210202	Тэтгэмжийн даатгал	13,268,796.00	15,507,068.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,770,859.00	13,071,523.61
210204	Ажилгүйдлийн даатгал	4,889,414.00	4,055,417.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,112,323.05	39,255,897.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	297,092,186.00	269,874,788.00
210301	Гэрэл, цахилгаан	11,167,114.00	7,095,996.00

**Булган сумын Ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210302	Түлш, халаалт	266,744,020.00	249,747,774.00
210303	Цэвэр, бохир ус	19,181,052.00	13,031,018.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,320,203.00</b>	<b>13,762,076.00</b>
210401	Бичиг хэрэг	2,918,260.00	3,471,280.00
210402	Тээвэр, шатахуун	1,405,950.00	1,767,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,244,213.00	2,199,941.00
210404	Ном, хэвлэл	100,880.00	278,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	671,000.00	634,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,979,900.00	5,410,495.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>114,168.00</b>	<b>294,682.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,168.00	294,682.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27,210,660.00</b>	<b>8,521,644.00</b>
210604	Урсгал засвар	27,210,660.00	8,521,644.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,252,100.00</b>	<b>424,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,252,100.00	424,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>200,000.00</b>	<b>949,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,000.00	625,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>171,259,611.26</b>	<b>128,690,490.55</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	551,200.00	54,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,804,900.00	829,540.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,903,511.26	127,806,650.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,409,553.50</b>	<b>128,317,507.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,986,800.00</b>	<b>37,258,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,586,800.00	33,978,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	3,280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,422,519.50</b>	<b>90,181,725.09</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,422,519.50	90,181,725.09
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,000,234.00</b>	<b>877,182.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,234.00	877,182.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>22,380,862.94</u></b>	<b><u>465,849,917.11</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>2,705,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	2,705,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>49,061,396.54</b>	<b>3,765,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,064,341.02	2,430,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	29,997,055.52	1,335,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-49,061,396.54</b>	<b>-1,060,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-26,680,533.60</u></b>	<b><u>464,789,917.11</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,013,890,700.00</b>	<b>2,234,894,750.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>2,435,450.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	2,435,450.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	2,435,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,435,450.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,013,890,700.00</b>	<b>2,232,459,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,700,834,000.00	1,954,507,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,669,000.00	4,613,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,120,000.00	720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,549,000.00	3,893,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	304,387,700.00	273,338,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,387,700.00	273,338,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,992,091,900.00</b>	<b>2,222,403,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,992,091,900.00</b>	<b>2,222,403,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,908,682,346.50</b>	<b>2,094,686,392.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,370,047,330.45	1,586,455,685.14
210101	Үндсэн цалин	910,770,284.31	849,051,680.88
210102	Нэмэгдэл	283,800,596.10	537,356,101.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	42,892,148.63
210104	Урамшуулал	175,476,450.04	157,155,754.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	170,784,267.05	198,457,013.77
210201	Тэтгэврийн даатгал	115,742,875.00	135,535,085.82
210202	Тэтгэмжийн даатгал	13,268,796.00	15,746,226.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,049,364.00	12,576,798.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,610,909.00	3,115,192.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,112,323.05	31,483,711.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	297,524,486.00	269,874,788.00
210301	Гэрэл, цахилгаан	11,599,414.00	7,095,996.00
210302	Түлш, халаалт	266,744,020.00	249,747,774.00
210303	Цэвэр, бохир ус	19,181,052.00	13,031,018.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,715,513.00	22,778,236.00
210401	Бичиг хэрэг	2,426,470.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,344,950.00	1,047,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,244,213.00	2,199,941.00
210404	Ном, хэвлэл	490,880.00	835,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	671,000.00	4,106,925.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,538,000.00	13,788,460.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,915,310.00	2,280,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	314,010.00	164,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,601,300.00	2,115,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,862,980.00	2,618,530.00
210604	Урсгал засвар	5,862,980.00	2,618,530.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,252,100.00	424,000.00
210702	Дотоод албан томилолт	1,252,100.00	424,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	200,000.00	1,997,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,000.00	1,673,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,380,360.00	9,800,290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,615,240.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,765,120.00	4,800,290.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,409,553.50</b>	<b>127,717,507.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,986,800.00	36,658,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,586,800.00	33,978,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	2,680,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	22,422,519.50	90,181,725.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,422,519.50	90,181,725.09
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,000,234.00	877,182.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,234.00	877,182.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>21,798,800.00</b>	<b>12,490,850.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,798,800.00</b>	<b>11,755,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,798,800.00</b>	<b>11,755,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	21,798,800.00	11,755,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,798,800.00	11,755,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-21,798,800.00</b>	<b>-11,755,400.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	735,450.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	735,450.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,534,272,484.62	00.00	-	-422,578,967.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,534,272,484.62	00.00	1,956,851,451.88	-422,578,967.26
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-180,420,110.05	-180,420,110.05
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	4,657,781,359.03	1,754,075,702.92
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	4,657,781,359.03	1,754,075,702.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	4,657,781,359.03	1,754,075,702.92
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	464,789,917.11	464,789,917.11
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	4,192,991,441.92	2,218,865,620.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,248,895,200.00	2,138,487,192.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,248,895,200.00	2,138,487,192.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,190,882,000.00	2,101,828,592.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,631,034,200.00	1,586,455,685.14
210101	Үндсэн цалин	856,854,500.00	849,051,680.88
210102	Нэмэгдэл	540,585,500.00	537,356,101.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,455,000.00	42,892,148.63
210104	Урамшуулал	179,139,200.00	157,155,754.04
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	220,113,600.00	198,457,013.77
210201	Тэтгэврийн даатгал	154,776,200.00	135,535,085.82
210202	Тэтгэмжийн даатгал	16,334,300.00	15,746,226.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,067,500.00	12,576,798.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,266,900.00	3,115,192.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,668,700.00	31,483,711.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,800,300.00	269,874,788.00
210301	Гэрэл, цахилгаан	11,600,000.00	7,095,996.00
210302	Түлш, халаалт	260,375,300.00	249,747,774.00
210303	Цэвэр, бохир ус	19,825,000.00	13,031,018.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,357,200.00	26,353,336.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	1,047,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,199,941.00
210404	Ном, хэвлэл	866,200.00	865,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,107,000.00	4,106,925.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,334,000.00	17,333,560.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	2,281,000.00	2,280,450.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	164,900.00	164,900.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,116,100.00	2,115,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,587,400.00</b>	<b>2,586,630.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,587,400.00	2,586,630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>852,100.00</b>	<b>424,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	852,100.00	424,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,456,200.00</b>	<b>1,997,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,132,200.00	1,673,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13400000.00</b>	<b>13399290.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,400,000.00	8,399,290.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58013200.00</b>	<b>36658600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,013,200.00</b>	<b>36,658,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,031,200.00	33,978,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	982,000.00	2,680,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,248,895,200.00</b>	<b>2,230,281,550.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,954,507,500.00</b>	<b>1,954,507,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,954,507,500.00	1,954,507,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>294,387,700.00</b>	<b>273,338,600.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	294,387,700.00	273,338,600.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>00.00</b>	<b>2,435,450.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	2,435,450.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>735,450.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>101.00</b>	<b>101.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	87.00	87.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Н.Янжмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 17-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25 -ний 08 өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдмийн өргөө цогцолбор сургууль нь суралцагчдын хөгжил, төлөвшлийг ханган, масс сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлж, сургалтын амжилт, чанарт ахиц гарган тогтвортой хөгжлийн боловсрол-ын үзэл баримтлалыг сургалтад нэвтрүүлнэ гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

- Багшийн заах арга, ур чадварыг сайжруулж, суралцагчдын хөгжил, төлөвшил, сурлагад ахиц гаргана.
- Хичээл сургалтын үйл ажиллагааг чанартай бэлтгэж, хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлнэ.
- Сургалтыг орчны стандарт шаардлагад нийцүүлэн, аюулгүй байдлыг хангаж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
- Эцэх эх асран хамгаалагчийн хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн 1159820.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23196.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн нийт зардлын 2 хувиар 46789.4 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 464831.8 мянган төгрөгөөр буюу 26.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна. Үүнд сургуулийн барилгын их засвар хийгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	735.5	735.5
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	84374.9	98855.5	14480.6
Үндсэн хөрөнгө	1669700.8	2119316.6	449615.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1754075.7</b>	<b>2218907.5</b>	<b>464831.8</b>

Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1754075.7	2218907.5	464831.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1754075.7</b>	<b>2218907.5</b>	<b>464831.8</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 735.5 мянган төгрөг нь тайлант онд байгууллагын ахмадын сан байгуулж, сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Авлага данс үлдэгдэлгүй,

Бараа материалын дансны үлдэгдэл 98855.5 мянган төгрөг болж 14480.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал байна. Тайлант онд хорио цээртэй холбоотой үйл ажиллагаа явуулаагүйгээс материалын үлдэгдэл өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2119316.6 мянган төгрөг болж 26.9 мянган төгрөгөөр өссөн нь барилгын их засварыг капиталжуулсан байна. Үндсэн хөрөнгийн данс урсгал төсвийн худалдан авалтаар 11755.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 410598.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, тоног төхөөрөмжийн данснаас 24683.8, тавилга эд хогшлын данснаас 2977.4 мянган төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2218907.5 мянган төгрөг болж 464831.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээ 155068.4, тайлант үеийн үр дүн 309763.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 492698.9 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого 271694.8 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 253673.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2248895.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1954507.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 294387.7, орон нутгийн төсвөөс 294387.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1954507.4, орон нутгийн төсвөөс 273338.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2435.4 мянган төгрөг нийт 2230281.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2140099.9 мянган төгрөгийг зарцуулж 90181.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2140099.9 мянган төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь цалингийн зардал 44578.5, нийгмийн даатгал 21656.6, байр ашиглалттай холбоотой 21925.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 720.0, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3893.2 нийт 4613.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, аудитаар өгсөн 2000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	400.0	1	400.0			
Албан шаардлага							
Зөвлөмж	2	2000.0	2	2000.0			
Нийт дүн							

/мянган.төг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17063.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11995.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 3854.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1214.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 17063.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11995.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 3854.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Хорио цээр тогтоосонтой холбоотой хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар явуулахыг түр зогсоосон хугацаанд багш ажилчдад хоолны хөнгөлөлт 11995.0 мянган

төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" байгууллагын дотоод журмын 10.2.10-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Ном хэвлэлийн зардлаас интернэтийн зардалд 250.3, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 3604.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1214.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар зардлын данстай холбоотой зориулалт бус зардал гарч байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1. Бараа материалын данстай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт: Бараа материалын дансанд 5 нэр төрлийн 1183.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС-16-д "Үндсэн хөрөнгө гэж дараах шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах" хөрөнгийг хэлнэ" гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн байна.

1.1. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, элэгдэл тооцогдохгүй байх,

1.2. Өгсөн зөвлөмж: НББОУС-16-д "Үндсэн хөрөнгө гэж дараах шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах" хөрөнгийг хэлнэ гэж заасны дагуу бүртгэх.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлэн ажиллана.

##### *2. Авлагын данстай холбоотой асуудал*

2.1.Илрүүлэлт: Өмнөх оны тайланд ХХОАТ-ын 30.6 мянган төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаж харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг үнэн зөв баталгаажуулж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлэн ажиллана.

##### *3. Дотоод хяналттай холбоотой асуудал:*

3.1. Илрүүлэлт: Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг нь тооллого явуулсан ч ажлын тайлан, тооллогын материалыг Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл: Хөрөнгө дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, тооллогын бүртгэлийг батлагдсан маягт зааврын дагуу бэлтгэж, тооллого хийсэн ажлын тайланг хэлэлцэн баталж хэвших.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлэн ажиллана.

#### *4. Байгууллагын удирдлагатай холбоотой*

4.1. Илрүүлэлт: Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны болон бусад хууль тогтоомж шинэчлэн гарсантай холбоотой өөрчлөлтүүд хийгээгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх "Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

4.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ